

2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA



*САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД*

АГУУЛГА

1 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

2 ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ДҮГНЭЛТ

3 ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ДҮГНЭЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

ТЗ	Тусгай зөвшөөрөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ҮХХЗБ	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага
МУТСТ	Мөнгө угаах, террорзмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
ГТСМТТ	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

2022.II

Үл хөдлөх эд хөрөнгө
зуучлалын байгууллага

284

Үнэт металл, үнэт чулууны,
эсхүл тэдгээрээр хийсэн
эдлэлийн арилжаа эрхлэгч



44



454

Нийт ирүүлсэн
ТЗ хүсэлтийн тоо

66

ТЗ

42

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын
байгууллага

ТЗ

24

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл
тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа
эрхлэгч


ТЗ хүсэлт
шийдвэрлэсэн
байдал

85%



УХХЗБ-ын тусгай
зөвшөөрлийн хүсэлт

96%



ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тусгай
зөвшөөрлийн хүсэлт

ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН
ХҮСЭЛТ

138

32

Эрх бүхий албан
тушаалтны
өөрчлөлт

34

ХНХ, ХЭ-ийн
өөрчлөлт

48

Агентын
өөрчлөлт

24

Хаяг байршил,
нэмэлт үйлчилгээ


ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

81%




Эрх бүхий албан
тушаалтны өөрчлөлт

71%




ХНХ, ХЭ-ийн
өөрчлөлт

81%



Агентын
өөрчлөлт


100%



Хаяг байршил, нэмэлт
үйлчилгээ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улаанбаатар хотын 6 дүүрэгт 281 ҮХХЗБ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79 ҮХХЗБ буюу 39 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр ҮХХЗБ-ууд нь Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.




Дүрслэл 3. Улаанбаатар хот дахь ҮХХЗБ-уудын тархалтын мэдээлэл./тоогоор/



Брокер
301

Агент
1,392


Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ҮХХЗБ нь нийт 301 брокер, 1,392 агенттайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс 298 брокер, 1,383 агент нь Улаанбаатар хотод, 3 брокер, 9 агент хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Брокер, агентын тархалтын мэдээллээс үзвэл Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.



Дүрслэл 4. Брокер, агентын тархалтын мэдээлэл /дүүргээр/

1.4. Үйл ажиллагааны төрөл.


Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах 5 төрлийн үйлчилгээг эрхэлж болох бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон нэр бүхий 284 хуулийн этгээдийг эрхэлж буй үйлчилгээний төрлөөр ангилан Дүрслэл 5-д харуулав.



Дүрслэл 5. ҮХХЗБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа


1.5. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл

Тайлант хугацаанд 284 ҮХХЗБ нь 418 хувьцаа эзэмшигчийн 5,866,630.7 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 71 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



	2021.II	2022.II	Өөрчлөлт дүнгээр	Хувь
Хувьцаа эзэмшигч	289	418	+129	45%
ХНХ-ийн хэмжээ	19,972,396.0	5,866,630.7	(14,105,765.3)	(71%)





Хүснэгт 1. ХНХ-ийн хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт /мян.төгрөг/



Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 83.2 хувь нь Монгол Улсын хөрөнгө оруулалттай бол үлдсэн 16.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай байна.


Дүрслэл 6. ҮХХЗБ-ын хөрөнгө оруулалтын байдал

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

	2021.II		2022.II	
	141 ҮХХЗБ	+43	184 ҮХХЗБ	1 хувьцаа эзэмшигчтэй ҮХХЗБ
	49 ҮХХЗБ	+26	75 ҮХХЗБ	2 хувьцаа эзэмшигчтэй ҮХХЗБ
	11 ҮХХЗБ	+7	18 ҮХХЗБ	3 хувьцаа эзэмшигчтэй ҮХХЗБ
	4 ҮХХЗБ	+3	7 ҮХХЗБ	4 болон түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй ҮХХЗБ

Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний мэдээлэл.

Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нийт хувьцаа эзэмшигчдийн 3 хувь буюу 12 хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд, 97 хувь буюу 406 хувьцаа эзэмшигч нь иргэн байна. Тайлант хугацаанд Хороонд бүртгэлтэй нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 31 хувь буюу 88 компани нь олон улсын франчайз эрхтэй байна. Үүнээс RE/MAX франчайз эрхтэй 66 компани, CENTURY 21 франчайз эрхтэй 21 компани, KELLER WILLIAMS франчайз эрхтэй 1 компани байна.





Дүрслэл 8. Франчайзын эрхтэй хуулийн этгээд /хувиар/

2. БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

2.1. Худалдах, худалдан авах үйлчилгээ

2022 оны эхний хагас жилийн байдлаар ҮХХЗ-ын байгууллага нийт 3,688 хэлцлээр, 765,039.04 м.кв талбай, 617,145,290.0 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагаанд зуучилсан байна.

2,085	Хэлцлийн тоо	3,688
2021.II		2022.II



Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон 284 ҮХХЗБ-аас ирүүлсэн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд борлуулан зуучилсан үл хөдлөх хөрөнгийн талбайн хэмжээ 1.6 дахин нэмэгдэж, борлуулалтын үнийн дүн 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант хугацаанд шинээр 79 ҮХХЗБ нэмэгдэж, хэлцлийн тоо өссөнтэй холбоотойгоос гадна тусгай зөвшөөрөлтэй 284 ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн 1 м.кв дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 1-1.2 дахин өссөн байгаа нь дээрх борлуулалтын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

2.2. Орон сууцны 1 м.кв дундаж үнэ

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 284 ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Чингэлтэй дүүрэгт орон сууцны 1 м.кв нь дунджаар 3,001,964.10 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй борлуулагдсан бол Сонгинохайрхан дүүрэгт 2,020,049.50 төгрөг буюу хамгийн бага дүнтэй борлуулагдсан байна. Тус тоон мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дүн 1-1.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.


	2021.II	2022.II	
Сүхбаатар	2,198,111.00	2,739,706.39	Сүхбаатар
Хан-Уул	2,138,399.00	2,864,442.92	Хан-Уул
Чингэлтэй	2,049,438.00	3,001,964.10	Чингэлтэй
Баянгол	2,019,843.00	2,948,303.65	Баянгол
Баянзүрх	1,939,864.00	2,390,346.27	Баянзүрх
Сонгинохайрхан	1,743,992.00	2,020,049.50	Сонгинохайрхан

2.3.Түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйлчилгээ

Тайлант хугацаанд нийт 1,777 хэлцлээр 172,057.24 м.кв талбай, 48,172,358.8 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагаанд зуучилсан байна.



Үйлчилгээний жил	Хэлцлийн тоо
2021.II	855
2022.II	1,777



2022.II

Хүчиргээний байр	Үнийн дүн /мянган төгрөгөөр/
Сүхбаатар	2,606,703.07
Хан-Уул	2,331,217.00
Чингэлтэй	1,698,644.37
Баянгол	1,506,301.11
Баянзүрх	1,632,120.30
Сонгинохайрхан	1,012,500.0

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 284 ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Сүхбаатар дүүрэгт орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн 1 сарын түрээсийн дундаж үнэ 2,606,703.07 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй байгаа бол, Сонгинохайрхан дүүрэгт 1,012,500.00 төгрөг буюу хамгийн бага үнийн дүнтэй байна.

Дүрслэл 10. Орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн 1 сарын түрээсийн мэдээ /төгрөг/

Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон 284 ҮХХЗБ-аас ирүүлсэн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагаанд зуучилсан үл хөдлөх хөрөнгийн талбайн хэмжээ 2 дахин нэмэгдэж, борлуулалтын үнийн дүн 6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант хугацаанд 79 ҮХХЗБ шинээр нэмэгдсэн, тухайн улиралд хийсэн хэлцлийн тоо 2 дахин өссөнтэй холбоотой байна.

3. САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Нийт хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн бүтэц

Хүснэгт 2. ҮХХЗБ-ын санхүүгийн тайлан мянган төгрөгөөр, хувиар

ҮЗҮҮЛЭЛТ	2021.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2022.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,969,915.7	9%	10,513,664.5	10%
Дансны авлага	6,414,877.7	10%	18,029,238.2	18%
Татвар, НДШ – ийн авлага	84,102.9	0%	346,368.9	0%
Бусад авлага	5,844,698.4	9%	8,326,073.2	8%
Бусад санхүүгийн хөрөнгө	0.0	0%	706,000.0	0%
Бараа материал	12,616,237.3	19%	21,211,169.4	21%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,486,914.3	4%	5,756,067.3	6%
Бусад эргэлтийн хөрөнгө	881,323.4	1%	908,973.2	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.0	0%	17,320,245.0	17%
Эргэлтийн хөрөнгийн дүн	34,298,419.6	52%	83,117,800.0	81%
Үндсэн хөрөнгө	18,422,009.4	28%	12,104,286.8	12%
Биет бус хөрөнгө	1,102,401.1	2%	1,533,783.7	1%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,791,493.2	9%	6,053,258.0	6%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,664,006.5	9%	46,026.2	0%
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	0%	23,756.8	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	720,843.3	1%	121,446.6	0%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,774,192.1	48%	19,882,558.1	19%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,072,611.7	100%	103,000,358.1	100%
Дансны өглөг	17,276,425.6	26%	43,654,742.3	42.4%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	2,618,628.8	4%	4,292,039.8	4.2%
Банкны богино хугацаат зээл	4,292,481.8	6%	1,163,925.9	1.1%
Хүүний өглөг	106,084.5	0%	465,030.4	0.5%
Ногдол ашгийн өглөг	0.0	0%	0.0	0%
Урьдчилж орсон орлого	6,587,413.0	10%	13,078,862.3	13%
Нөөц /өр төлбөр/	11,947.9	0%	318,316.6	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	9,776,582.8	15%	15,611,488.7	15.2%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	65,000.0	0%	108,538.7	0%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	40,734,587.8	62%	78,692,944.7	76.4%
Урт хугацаат өр төлбөр	25,200.0	0%	101,034.8	0%
Урт хугацаат зээл	5,049,313.7	8%	7,099,667.5	7%
Хойшлогдсон татварын өр	0.0	0%	420.9	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	201,378.6	0%	2,312,418.8	2.2%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,333,178.5	8%	9,513,542.0	9.2%
Өр төлбөрийн нийт дүн	46,067,766.3	70%	88,206,486.8	85.6%
Өмч	19,972,396.7	30%	5,866,630.7	5.7%
- хувийн	19,972,396.7	30%	5,866,630.7	5.7%
Нэмж төлөгдсөн капитал	12,530.0	0%	0.0	0%
Халаасны хувьцаа	0.0	0%	308.2	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.0	0%	56,652.0	0.05%
Эздийн өмчийн бусад хэсэг	785,374.8	1%	1,038,155.5	1%
Хуримтлагдсан ашиг	-765,460.2	-1%	7,832,124.9	7.6%
Эздийн өмчийн дүн	20,004,845.4	30%	14,793,871.3	14.4%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	66,072,611.7	100%	103,000,358.1	100%

3.2. Нийт хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид гарсан өөрчлөлт

2021 оны эхний хагаст

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 205 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд нийт 289 хувьцаа эзэмшигчийн 19,972,396.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 66,072,611.7 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Нийт хөрөнгөд эзлэх хувь




2022 оны эхний хагаст

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 284 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд нийт 418 хувьцаа эзэмшигчийн 5,866,630.7 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 103,000,358.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Нийт хөрөнгөд эзлэх хувь



Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд



3.3. Орлого, зарлага, ашигт ажиллагаа

Хүснэгт 3. ҮХХЗБ-уудын орлого, зарлагын бүтэц /мян.төгрөг, хувиар/

Үзүүлэлтүүд	2021.II	2022.II	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	19,930,035.3	20,106,257.9	176,222.6	1%
Борлуулалтын орлого (цэвэр)	19,496,399.7	18,126,860.5	-1,369,539.2	-7%
Түрээсийн орлого	242,674.2	333,886.8	91,212.6	38%
Хүүний орлого	38,336.2	80,155.6	41,819.4	109%
Эрхийн шимтгэлийн орлого	10,851.0	0.0	-10,851.0	-100%
Бусад олз*	0.0	1,105,652.0	1,105,652.0	+100%
Бусад орлого	141,774.2	459,703.1	317,928.9	224%
Нийт зардал	21,532,769.4	19,248,436.3	-2,284,333.1	-11%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	9,846,107.4	6,906,460.7	2,939,646.7	-30%
Борлуулалт, маркетингийн зардал	3,149,423.5	1,331,205.7	-1,818,217.8	-58%
Ерөнхий ба удирдлагын зардал	7,282,234.5	9,620,128.7	2,337,894.2	32%
Санхүүгийн зардал	577,288.8	843,837.1	266,548.3	46%
Бусад зардал	677,715.2	423,765.2	-253,950.0	-37%
Бусад гарз	8,355.4	0.0	-8,355.4	-100%
Татварын зардал	167,582.8	123,039.0	-44,543.8	-27%
Цэвэр ашиг	-1,306,762.0	857,821.6	2,164,583.6	-166%

Бусад олз*- Гадаад валютын ханшийн зөрүүний олз, үндсэн хөрөнгө данснаас хассаны олз,

Орлогын бүтэц

Тайлант хугацааны нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувь буюу 176,222.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 20,106,257.9 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 90 хувийг борлуулалтын орлого буюу үйлчилгээний шимтгэлийн орлого, 4 хувийг үйл ажиллагааны бусад орлого, 6 хувийг үйл ажиллагааны бус орлого тус тус эзэлж байна.

Зардлын бүтэц

ҮХХЗБ-ын нийт зардлын хэмжээ 19,248,436.3 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 2,284,333.1 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт зардлын бүтцэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 36 хувь, борлуулалт, маркетингийн зардал 7 хувь, ерөнхий ба удирдлагын зардал 50 хувь, үндсэн үйл ажиллагааны бус зардлууд 7 хувийг тус тус эзэлж байна. Зардлын бүтцээс харахад тайлант хугацаанд ҮХХЗБ-ын ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оны мөн үеэс 32 хувь буюу 2,337,894.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ашигт ажиллагаа

2022 оны хагас жилийн тайлангаар нийт орлогын хэмжээ 20,106,257.9 мянган төгрөг, нийт зардал 19,248,436.3 мянган төгрөгт хүрч, тайлант хугацаанд 857,821.6 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

4.ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

4.1. Бүртгэл зөвшөөрлийн талаар

2022 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 284 хуулийн этгээд нь 301 брокер, 1,392 агенттайгаар Монгол Улсын 3 аймаг, 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Тайлант хугацаанд Хорооны 12 удаагийн хуралдаанаар 59 асуудлыг хэлэлцүүлснээс 38 компанид ҮХХЗБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 16 ҮХХЗБ-д ХНХ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл, 3 ҮХХЗБ-д оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгож, нэр бүхий 2 ҮХХЗБ-ын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлүүлсэн.

4.3. Борлуулалтын талаар

Тайлант хугацаанд 284 ҮХХЗБ нь нийт 3,688 хэлцлээр, 765,039.04 м.кв талбай, 617,145,290.0 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагаанд зуучилсан бол нийт 1,777 хэлцлээр 172,057.24 м.кв талбай, 48,172,358.8 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагаанд зуучилж, 18,126,860.4 мянган төгрөгийн орлого олсон байна.

ҮХХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Чингэлтэй дүүрэгт орон сууцны 1 м.кв дундаж үнэ 3,001,964.10 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй борлуулагдсан бол Сонгинохайрхан дүүрэгт 2,020,049.50 төгрөг буюу хамгийн бага дүнтэй борлуулагдсан байна. Тус тоон мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дүн 1-1.2 дахин өссөн байна. Энэ нь нэг талаас барилгын бараа материалын үнэ болон тээврийн зардал өсөж, нөгөө талаас орон сууцны эрэлт нэмэгдсэнтэй холбоотой.

4.2. ХНХ, хувьцаа эзэмшигчдийн талаар

Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын 418 хувьцаа эзэмшигчийн 3 хувь буюу 12 хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд, 97 хувь буюу 406 хувьцаа эзэмшигч нь иргэн байна. Тайлант хугацаанд 284 ҮХХЗБ нь 5,866,630.7 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 хувиар буурсан байна. Энэ нь нэр бүхий 2 хуулийн этгээдийн ҮХХЗБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

4.4. Нийт хөрөнгийн бүтцийн талаар


2022 оны эхний хагас жилийн байдлаар 284 ҮХХЗБ-ын нийт хөрөнгө 103,000,358.1 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56 хувь буюу 36,927,746.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь тайлант хугацаанд шинээр 79 ҮХХЗБ нэмэгдсэнтэй холбоотой байна. Нийт хөрөнгийн 81 хувийг эргэлтийн хөрөнгө, 19 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол эздийн өмч нийт хөрөнгийн 14 хувийг, өр төлбөр 86 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацааны байдлаар ҮХХЗБ-ын нийт орлого 20,106,257.9 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувь буюу 176,222.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол нийт зардал 19,248,436.3 мянган төгрөгт хүрч, 11 хувь буюу 2,284,333.1 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт зардлын бүтцэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 36 хувь, борлуулалт, маркетингийн зардал 7 хувь, ерөнхий ба удирдлагын зардал 50 хувь, үндсэн үйл ажиллагааны бус зардлууд 7 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд ҮХХЗБ-ууд нь 857,821.6 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

1. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


1.1. Зах зээлийн ерөнхий мэдээлэл

Тайлант улиралд буюу 2022 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанканд нийт 482 харилцагч алт тушааснаас 57 хувь буюу 274 нь аж ахуйн нэгж, 43 хувь буюу 208 нь иргэд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Монголбанканд алт тушаах иргэд, аж ахуйн нэгж 10 хувиар буурсан байна.



Дүрслэл 10. Монголбанканд алт тушаасан харилцагчид хувиар.


1.2. Монголбанкны худалдаж авсан алтны хэмжээ



Дүрслэл 11. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тн)

Монголбанк 2022 оны эхний хагаст 7.9 тонн алтыг 1.3 их наяд төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдаж авсан алтны нийт үнийн дүн хэвээр боловч алтны хэмжээ 15 хувь буюу 1.4 тонноор буурсан байна. Энэ нь 1 гр алтны ханшийн дундаж үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.6 хувь буюу 17,516.60 төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

1.3. Бүртгэл, зөвшөөрлийн талаар



Дүрслэл 12. Тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн мэдээлэл.

Тайлант улирлын байдлаар нийт 44 хуулийн этгээд, 454 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж буй нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд 15.7 хувь, иргэд 9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.



Тайлант хугацаанд нэр бүхий 1 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд 4 салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг олгосон.

1.4. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагааны төрөл




Хорооноос ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 44 хуулийн этгээд, 454 иргэний 50 хувь буюу 22 хуулийн этгээд, 249 иргэн нь үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч байна.



1.5. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тархалтын мэдээлэл


Тайлант улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон 44 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, 454 иргэн нь Монгол Улсын 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс, ҮМҮЧЭТХЭАЭ 91 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байсан бол үлдсэн 363 иргэн, 43 хуулийн этгээд Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдэд илүү төвлөрөлттэй байна.



Дүрслэл 13. МУ-д үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тархалтын мэдээлэл./иргэн, хуулийн этгээд/

2.БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

2.1. Үнэт металл /алт/-ын борлуулалтын мэдээ



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 703.1 кг алтыг 117,276,662.6 мянган төгрөгөөр худалдан авч, 754.7 кг алтыг 129,389,052.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 60 хувь буюу 191,352,712.7 мянган төгрөгөөр, худалдаж авсан алтны хэмжээ 55 хувь буюу 143,637,371.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Дүрслэл 15. Алтны худалдан авалтын хэмжээ /мянган төгрөг/

2.2. Үнэт металл /мөнгө/-ын борлуулалтын мэдээ



Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 95.4 кг мөнгийг 3,617,318.1 мянган төгрөгөөр худалдан авч, 37.5 кг мөнгийг 130,487.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдаж авсан мөнгөний хэмжээ 3,381,256.0 мянган төгрөгөөр, худалдсан мөнгөний хэмжээ 25,767.7 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 16. Мөнгөний худалдан авалтын хэмжээ /мянган төгрөг/

2.3. Үнэт металлаар хийсэн эдлэлийн арилжааны мэдээ

Тайлант хугацаанд нийт 264 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 4,586 харилцагчид 16,555 бүтээгдэхүүнийг 4,858,578.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэхүү мэдээг санхүүгийн анхан шатны баримт болох цахим төлбөрийн И-Баримтын мэдээнд тулгуурлан гаргасан болно.



3. САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Нийт хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн бүтэц

Хүснэгт 5. ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн санхүүгийн тайлан /мян.төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2022.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,254,369.0	12%	6,831,145.8	27.8%
Дансны авлага	3,463,536.5	12%	928,883.1	3.7%
Татвар, НДС – ийн авлага	248,287.5	1%	375,878.9	1.5%
Бусад авлага	1,380,243.4	5%	168,864.1	0.7%
Бусад санхүүгийн хөрөнгө	0.0	0%	0.0	0%
Бараа материал	7,848,850.0	28%	8,462,554.2	34.5%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,194,872.6	8%	3,946,093.4	16.1%
Бусад эргэлтийн хөрөнгө	202,436.5	1%	41,245.6	0.2%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,331,425.1	5%	0.0	0%
Эргэлтийн хөрөнгийн дүн	19,924,020.6	72%	20,754,665.1	85%
Үндсэн хөрөнгө	7,120,856.0	26%	3,642,485.5	15%
Биет бус хөрөнгө	241,170.9	1%	70,868.9	0%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	0%	54,593.1	0%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	574,432.7	2%	0.0	0%
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,070.8	0%	0.0	0%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,937,530.4	28%	3,767,947.5	15%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	27,861,551.0	100%	24,522,612.6	100%
Дансны өглөг	3,656,556.8	13%	11,696,282.2	47.6%
Цалингийн өглөг	61,425.7	0%	1,529.5	0%
Татварын өр	448,713.4	2%	522,320.7	2.1%
НДС - ийн өглөг	9,246.2	0%	85,020.7	0.4%
Банкны богино хугацаат зээл	1,668,532.4	6%	1,635,123.2	6.7%
Хүүний өглөг	98,229.8	0%	0.0	0%
Урьдчилж орсон орлого	4,468,085.6	16%	3,706,565.0	15.1%
Нөөц /өр төлбөр/	13,348.4	0%	0.0	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	4,479,973.9	16%	2,240,348.0	9.1%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,904,112.1	53%	19,887,189.2	81%
Урт хугацаат өр төлбөр	324,400.5	1%	0.0	0%
Урт хугацаат зээл	4,685,583.1	17%	1,184,421.0	5%
Бусад урт хугацаат өр төлбөр	177,481.3	1%	0.0	0%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,863,064.4	17%	1,184,421.0	5%
Өр төлбөрийн нийт дүн	19,767,176.4	71%	21,071,610.1	86%
Өмч	8,458,819.0	30%	9,334,419.1	38%
- хувийн	8,458,819.0	30%	9,334,419.1	38%
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.1	8%	0.0	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	250,855.8	1%	0.0	0%
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	15,955.3	0%	0.0	0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,686,351.3	6%	260,956.8	1%
Хуримтлагдсан ашиг	4,595,839.0	-16%	-6,144,373.4	-25%
Эздийн өмчийн дүн	8,094,374.5	29%	3,451,002.5	14%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	27,861,550.9	100%	24,522,612.6	100%

3.2. Нийт хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид гарсан өөрчлөлт

2021 оны эхний хагаст

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсан бөгөөд нийт 57 хувьцаа эзэмшигчийн 8,198,319.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 27,681,550.9 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.


Нийт хөрөнгөд эзлэх хувь




2022 оны эхний хагаст

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 44 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсан бөгөөд нийт 74 хувьцаа эзэмшигчийн 9,334,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 24,522,612.6 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Нийт хөрөнгөд эзлэх хувь



Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хүснэгт 6. ҮМҮЧЭТХЭАЭ-дийн орлого, зарлагын бүтэц /мян.төгрөг, хувиар/

Үзүүлэлтүүд	2021.II	2022.II	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	7,922,087.40	4,247,940.6	-3,674,146.8	-46%
Борлуулалтын орлого (цэвэр)	7,788,673.9	3,979,185.9	-3,809,488.0	-49%
Түрээсийн орлого	115,718.2	268,754.8	153,036.6	132%
Бусад орлого	17,695.3	0.0	-17,695.3	-100%
Нийт зардал	10,564,983.7	7,284,946.3	-3,280,037.4	-31%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,899,331.3	1,443,626.6	-2,455,704.7	-63%
Борлуулалт, маркетингийн зардал	872,598.4	378,048.0	-494,550.4	-57%
Ерөнхий ба удирдлагын зардал	5,423,887.3	5,317,920.0	-105,967.3	-2%
Санхүүгийн зардал	335,528.1	84,634.1	-250,894.0	-75%
Бусад зардал	33,638.6	2,130.2	-31,508.4	-94%
Бусад гарз	5,977.0	11,417.4	5,440.4	91%
Татварын зардал	83,224.2	47,170.3	-36,053.9	-43%
Цэвэр ашиг	-1,306,762.0	-3,037,005.7	-1,730,243.7	132%

Орлогын бүтэц

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тайлант хугацаанд нийт орлого 4,247,940.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46 хувь буюу 3,674,146.8 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 94 хувийг борлуулалтын орлого, 6 хувийг түрээсийн орлого эзэлж байна.

Зардлын бүтэц

Тайлант хугацаанд нийт зардлын хэмжээ 7,284,946.3 мянган төгрөгт байгаа нь өмнөх оны мөн үеэс 31 хувь буюу 3,280,037.4 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 20 хувь, борлуулалт, маркетингийн зардал 5 хувь, ерөнхий ба удирдлагын зардал 73 хувь, үндсэн үйл ажиллагааны бус зардлууд 2 хувийг тус тус эзэлж байна.

Ашигт ажиллагаа

2022 оны эхний хагас жилийн байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нийт орлого 4,247,940.6 мянган төгрөг, нийт зардал 7,284,946.3 мянган төгрөг, тайлант үеийн алдагдал - 3,037,005.7 мянган төгрөг байна. Тайлант хугацааны байдлаар орлого 46 хувиар, зардал 31 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

4. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

4.1. Бүртгэл зөвшөөрлийн талаар

Тайлант улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 44 хуулийн этгээд, 454 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлсэн байна.

Тайлант хугацаанд Хорооны 12 удаагийн хуралдаанаар 5 хуулийн этгээд, 18 иргэнд тусгай зөвшөөрөл олгож, 1 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлүүлсэн.

Мөн Хорооны даргын тушаалаар нэр бүхий 1 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд 4 салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг олгосон.

4.4. Нийт хөрөнгийн бүтцийн талаар

2022 оны эхний хагас жилийн байдлаар 498 ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нийт хөрөнгө 24,522,612.6 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувь буюу 12,327,610.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгийн 82 хувийг эргэлтийн хөрөнгө, 18 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол эздийн өмч 14 хувийг, өр төлбөр 86 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацааны байдлаар нийт орлого 4,247,940.6 мянган төгрөгт, нийт зардал 7,284,946.3 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс орлого 46 хувиар, зардал 31 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, тайлант үеийн орлого өмнөх оны мөн үеэс 46 хувь буюу 3,674,146.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант улирлын цэвэр ашиг /алдагдал/ -3,037,005.7 мянган төгрөгт хүрэхэд нөлөөлсөн байна.

4.2. ХНХ, хувьцаа эзэмшигчдийн талаар

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ 44 хуулийн этгээд нь 74 хувьцаа эзэмшигчийн 9,334,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 хувьцаа эзэмшигч шинээр нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 14 хувь буюу 1,136,100.1 мянган төгрөгөөр өссөн байна.

4.3. Борлуулалтын талаар

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 703.1 кг алтыг 117,276,662.6 мянган төгрөгөөр худалдан авч, 754.7 кг алтыг 129,389,052.3 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 60 хувь буюу 191,352,712.7 мянган төгрөгөөр, худалдаж авсан алтны хэмжээ 55 хувь буюу 143,637,371.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 95.4 кг мөнгийг 3,617,318.1 мянган төгрөгөөр худалдан авч, 37.5 кг мөнгийг 130,487.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдаж авсан мөнгөний хэмжээ 3,381,256.0 мянган төгрөгөөр, худалдсан мөнгөний хэмжээ 25,767.7 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 264 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 4,586 харилцагчид 16,555 бүтээгдэхүүнийг 4,858,578.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үеэс 89.4 хувь буюу 2,294,346.1 мянган төгрөгөөр өссөн байна.